

АЖЛЫНХУУДАС 2

(унших)

Алхам 1. Эхийг анхааралтай уншаад зургийг үйлтэй нь тохируулаарай.

Ховдог ходоод

Нүд, ам, хамар, чих, гар хоорондоо ийнхүү ярьж байна гэнэ.

Нүд “Намайг харж байхад хамаг л гоё хоол унд, амттан шимттэн ходоод руу ороод байна” гэхэд ам “Харин тийм, би дөнгөж амтлаад л хоолой руу явуулдаг” гэж гомдолложээ. Хамар “Чи харин ч амтыг нь мэддэг юм байна. Би бол сайхан хоолыг дөнгөж үнэрлэхээс цаашгүй” гэлээ. Тэгтэл гар “Би бүгдийг нь барьж үздэг ч хэзээ ч өөрөө иддэггүй. Бас гомдолтой байдаг” гэв.

Тиймээс тэд “Ходоодонд саад болж хоол өгөхөө больё” гэж тохирчээ.

Эзэн өглөө босоод цай уух гэтэл нүд эсэргүүцэж, хоол руу муухай харав. Хамар эсэргүүцэж үнэрлэхгүйг хичээн, ам эсэргүүцэж ангайхгүй жимийж, гар эсэргүүцэж халбагаа зориуд алдаж унагаажээ.

Ингээд эзэн нь хоол идэж чадаагүй тул ходоод нь хонхолзож, нүд нь бүрэлзэн, чих нь шуугьж, хамар нь хатаж, гар нь салгалж гэнэ. Ийнхүү тэд хоол гэж зөвхөн ходоодонд тустай зүйл биш гэдгийг ойлгожээ.

үнэрлэх

амтлах

сонсох

барих

харах

